

Японы төрийн албаны ёс зүйн шинэтгэл: “Japan Inc ба түүний уналт”

Ч.Өлзийсайхан

Доктор, дэд профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим

Д.Ундрах

Доктор, дэд профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим

Түлхүүр үгс: төрийн алба, ёс зүйн шинэчлэл, Япон улсын хөгжил

Хураангуй: Төрт ёсны бэхжилт нь төрийн албан хаагчдийн ёс зүй, хариуцлагын тогтолцоог хэрхэн ханган ажиллаж буйгаар тодорхойлогдож байгааг хөгжингүй орнуудын туршлагаар харуулахыг зорьж, энэ удаа Япон улсын төрийн албан хаагчдын ёс зүйн хуулийн хүрээнд тодруулахыг зорилгоо.

Бусдын туршлагаас суралцаж, алдааг нь давталгүй тойрч гарах боломж хөгжиж буй улс орнуудад бий. Гацаанаас гарах гарц хайж, гарцаагүй сийрэг сэтгэх шаардлага өнөөдөр бидэнд тулгараад байна. Алдаа оноогоо дэнслэхдээ тогтолцоо, хууль дүрэм гэхээсээ илүү мөн чанар, хүн ёс руу хандах цаг болсон. Тогтолцоо сайн муу, тохирох, эс тохирох талтай ч төрийн механизмыг хөдөлгөх хүч нь хүн тул түүнийг хэрхэн мөс чанартай, эзэн сэтгэлтэй байлгах тал дээр өнөөдөр бид анхаарах ёстой. Хөгжил дэвшлийн жишиг загварт тооцогдож буй улсуудын амжилтын нууц, хөгжлийн түлхүүрийг хүн төвтэй бодлого, хүнтэй тооцох хариуцлага, хүнд хүргэх үйлчилгээ гэж өнөөдөр ярих болжээ. Тэгвэл Японы улс төрийн системийн тулах нэг багана болох бюрократ тогтолцоонд ёс зүйт албан хаагчдыг бүрдүүлснээр төрт ёсны дархлаагаа хэрхэн хадгалж буй талаар энэхүү өгүүллээр хөндөж, цаашид ч төрийн албаны шинэчлэл, тэр дундаа ёс зүйн чиглэлийн шинэтгэлийн асуудлыг өргөн цар хүрээтэй судлаж, судлаачид, төрийн албан хаагчидтай хуваалцахыг зорьж байна.

Нийтэд тогтсон түгээмэл ойлголтоор бол Япон улсад төрийн эрх мэдэл засаглагч элитүүд, Либерал Ардчилсан Нам (ЛАН-төр баригч улс төрийн нам), томоохон бизнес бүлэглэлүүдээс бүрдэх “Засаглагч гурвал” буюу “Япон маягийн корпорац”³⁸-ийнгарт төвлөрдөг гэж үзсээр иржээ. Засаглалын эдгээр гурвал эдийн засгийн өндөр өсөлтийг хангахын тулд нэгдэн ажилладаг бол, Японы цэрэг, батлан хамгаалах бодлого, гадаад бодлогын асуудлыг ерөнхийд нь АНУ хангаж ирсэн” гэж ойлгосоор ирсэн³⁹. Засаглалын энэхүү гурвалд бюрократ тогтолцоо нь хамгийн хүчтэй тоглогч гэж үзэх явдал амь бөхтэй оршдог бөгөөд үүнийг удаан хугацаагаар хэвшиж тогтсон уламжлалт тогтолцоо (Японы хууль тогтоох бхйгууллага болох Үндэсний Ассамблейгээс ч хавьгүй өмнө бий болсон), төрт ёсны нэр хүнд, туршлагатай нь холбон тайлбарладаг. Онол ёсоор бюрократ тогтолцоо, улс төр ба эдийн засгийн элитүүдээс бүрдэх уг “төмөр гурвал”-аар Японы “эдийн засгийн хөгжлийн гайхамшиг”-ийг тайлбарлах ёстой гэж үздэг төдийгүй өнөөгийн нийгэмд тулгамдаад буй асуудлыг ч мөн эдгээртэй холбон тайлбарлавал зүйтэй гэж үздэг судлаачид цөөнгүй⁴⁰.

Гэвч өнөөг хүртэл яригдсаар буй “засаглагч гурвал” буюу “Japan Inc” загварыг нухацтай авч үзэх шаардлагатай. Цомхон, чадварлаг элитүүд асуудлыг шийдэх боломжтой байсан 1960-аад оны нөхцөл байдал өнөөгийн цаг үеэс хол ялгаатай, үйл явдал ч хурдан хувьсч өөрчлөгдөж

³⁸“Japan Inc” (Japan Incorporate) буюу Япон маягийн нэгдэл гэсэн утгатай.

³⁹Hayao, K. (1993). The Japanese prime minister and public policy. Pittsburg: University of Pittsburg Press.

⁴⁰Kerbo, H.R&McKinstry, J.A. (1995). Who rules Japan? Westport: Praeger Publishers.

байна. Асуудлын мөн чанрыг “1955 оны тогтолцоо” гэж нэрлэсэн судлаач Х.Куртисын тайлбар сонирхол татдаг⁴¹. Японы ЛАН-ын урт хугацааны ноёрхол 1955 онд хэд хэдэн консерватив намууд ЛАН-ы дээвэр дор нэгдсэн үеэс эхтэй гэж үздэг. Куртисын хэлсэнчлэн, “1955 оны тогтолцоо” гэгдэх энэхүү тогтолцоог бүрдүүлэхэд харилцан хамааралтай 4 тулгуур багана байсан гэж үзээд, үүнд: -эдийн засгийн хүчирхэг гүрэн болох зорилгын дор нэгдсэн ард олны нэгдмэл санаа бодол; -улс төрийн намуудтай нягт холбогдсон сонирхолын томоохон бүлэглэлүүд; -нэг намын давамгайлал; -нэр хүндтэй, хүчирхэг бюрократ тогтолцоог багтаажээ.

Улс төр, нийгмийн амьдралд эдгээр 4 хүчирхэг тулгуур бүрдсэнээр дэлхийн 2-р дайны төгсгөлд эвдрэн сүйдсэн эх орноо 1980-аад оны босгон дээр дэлхийн эдийн засгийн тэргүүлэх гүрний хэмжээнд хүргэж чадсан их амжилтын түүхийг бүтээлцсэн. Гэвч амжилтын араас дагалдах сүүдэр 1970-аад онд эхэлж, 1980-аад оны сүүлийн хагаст бий болсон эдийн засгийн “хөөсөн өсөлт”-ийн жилүүдэд үргэлжилж, 1990-ээд оны эхээр өсөлтийн хөөс задрах үед эрчээ авчээ. Дотоод динамик хийгээд гадаад эдийн засгийн шахалтын улмаас “1955 оны тогтолцоо”-г бүрдүүлэгч элементүүд аажмаар суларч эхэлжээ. Үүсэн бий болсон хэдэн хэдэн хүчин зүйлс үүнд нөлөөлсөн гэж үзэх талтай. 1-д, эдийн засгийн амжилтад хүрэх зорилго биелэгдсэнээр уг зорилгын суурь зөвшилцөл үгүй болов. Олон нийтийн санаа бодол, оюун санааны удирдагчдын аль алинд шинэчлэлийн төлөөх шинэ хандлага бүрэлдсэн гэж үздэг⁴². 1990-ээд оноос Японы элитүүд улс төр, эдийн засгийн реформыг эрс шийдвэртэй хэрэгжүүлэхгүй бол Японы улсын хөгжлийн хувь заяа муугаар эргэх аюултай гэж үзэх болов. Хэдий тийм ч шинэтгэлийн үйл явц хавьгүй аядуу, сул байв. Харин ч чинээлэг, иргэний нийгэмд хөтлөж оруулсан системийг эрс шинэчлэх тухайд ард иргэдийн санаа бодол ихээхэн аядуу байж, эдийн засгийн асуудалд л анхаарлаа хандуулвал зохино гэж үзэж байв. Эндээс шинэтгэлийн чиглэлийн тухайд нэгдсэн ойлголцол, байр суурь дутмаг байсан нь харагдана. 2-т, томоохон бизнесүүд, үйлдвэрчний эвлэл, хөдөө аж ахуйн фермерүүдийг төлөөлөх сонирхлын бүлгүүдээс улс төрийн нам, засгийн газарт үзүүлэх нөлөөлөл хавьгүй их байдаг. Японы улсын эдийн засгийн амжилтад хүрэх улс орны зорилго биелэгдэж, аж үйлдвэржсэн нийгмээс “аж үйлдвэржсэний дараах”(пост индустриал)-д шилжсэнээр бизнес, фермерүүд болон Үйлдвэрчний эвлэлүүдийн ашиг сонирхол улам бүр ялгарч хоорондын нэгдэл нягтрал сулрах болов. Куртис энэхүү хувьслыг “сонирхлын бүлгийн улс төр”-өөс тусгай сонирхолт улс төр” рүү шилжсэн шилжилт хэмээн нэрлэжээ.⁴³ Парламентийн гишүүдэд ялангуяа эрх баригч ЛАН-ын тодорхой бодлогын асуудлаар мэргэшсэн, холбогдох төрийн яам, агентлагын албан хаагчидтай ойрын хэлхээ холбоо тогтоосон гишүүдэд тусгай ашиг сонирхлыг төлөөлөх агентийн үүрэг гүйцэтгэх, бюрократууд болон сонирхолын бүлгүүдийн хооронд зуучлах боломж олгодог аж. Ийнхүү дээр дурдагдсан “төмөр гурвал”-ын бүтэц бодлогын түвшинд шинэчлэн зохион байгуулагдахад хүрчээ. 3-т, ЛАН-ын удаан хугацааны ноёрхол энэхүү бодлого, байр суурь удаан хугацаанд үргэлжлэх, “төмөр гурвал”-ыг бэхжих боломж олгосон нь дамжиггүй. Гэвч ЛАН 1989 онд Парламентийн дээд танхимд, улмаар 1993 онд доод танхимд өөрсдийн дийлэнхи олонхийн байр сууриа алдсан явдал дээрх хүчирхэг бодлогын залгамж байдал алдагдахад нөлөөлсөн. 4-т, Тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн, сонгогчдын саналыг татахыг эрмэлздэг, өртөг ихтэй сонгуулийн кампанийн санхүүжилт босгохыг тулд ажилладаг “явцуу” сонирхол бүхий улс төрчдийг бодвол бюрократууд нь япон үндэстний эв нэгдэл, хүч чадлын илэрхийлэл, үндэсний ашиг сонирхолыг хадгалан хамгаалагч хэмээн ойлгогдож хүндлэгдсээр ирсэн. Японы төрийн албан хаагчдын байр суурийг Куртис: “Японы хамгийн нэр хүнтэй их дээд сургуулиуд(ялангуяа Токиогийн их сургуулийн хуулийн салбар)-ийн хамгийн шилдэг төгсөгчдөөс уралдаант шалгалтаар шигшин сонгогдсон бюрократ албан хаагчид нь өндөр ёс суртахуунтай, үүрэг хариуцлагатай, ур чадвартай, шударга ёсны ухамсартай хүмүүс байдаг. Бардам, ихэрхүү ч гэмээр харагдах тэдгээртөрхийн цаана ард түмэндээ үйлчлэх үүргээ

⁴¹ Curtis, G.L. (1999). The logic of Japanese politics. New York: Columbia University Press. 39-40.

⁴² Curtis, 1999: 40-43.

⁴³ Curtis, 1999: 44. Үүнийг Япон хэлэнд *zokuxэмээн томьёолдог*.

ямар ч материаллаг сонирхлоор худалдахгүй гуйвшгүй бат итгэл, зүтгэл байдаг” хэмээн тодорхойлсон байдаг⁴⁴. Гэвч 1990-д онд цөөнгүй тооны бодлогын алдаа, төрийн албан хаагчдын нэр холбогдсон ёс зүйн алдаатай үйлдлийн дуулиан шуугиан Японы төрийн албаны нэр хүндийг унагахад нөлөөлөөд⁴⁵ зогсохгүй төрийн албаны бодит эрх мэдэл ч хязгаарлагдах болсон нь тодорхой ашиг сонирхол хамгаалахаар ажиллах болсон парламентийн гишүүдийн шинэ хандлага, үйл ажиллагаатай ч холбоотой.

1990-д оны шинэтгэлийн тухай хэлэлцүүлэг

Эдийн засгийн бэрхшээл болон 1955 оны тогтолцооны согог дутагдлууд нийгмийн дээд давхаргынхны хүрээнд шинэтгэлийн талаар хүчтэй хэлэлцэхэд хүргэжээ. 1993 онд Хосокавагийн засгийн газрыг 8 намын оролцоотой бүрдүүлэхэд 1955 оноос хойш анх удаа ЛАН засгийн газрын бүтцэд багтсангүй. Ерөнхий сайд Хосокавагийн засгийн газар жил хүрэхгүй хугацаанд ажиллахдаа улс төрийн намуудад олгодог хандивыг хязгаарлах, иргэдээс намуудад өгөх мөнгөн дэмжлэгийг нэмэгдүүлэх, авлига хээл хахуулийн хэргийн шийтгэлийг чангатгах, сонгуулийн реформ хийх зэрэг шинэтгэлийн зоримог санаачлагууд дэвшүүлж, олонхийг нь ажил хэрэг болгож чадаагүй ч сонгуулийн хуулийн хүрээнд нэлээд зүйлийг хэрэгжүүлж амжсан аж. Ингэхдээ Парламентийн доод танхимийн 200 гишүүнийг бүс нутгийн пропорциональ төлөөллийн тойргоос сонгож, 300 гишүүнийг нэг мандаттай тойргоос сонгогдохоор болгож өөрчилсөн юм.

Дайны дараах Японы засаг захиргааны өөрчлөлтийн түүхийг сөхвөл засгийн газрыг боловсон хүчний тоо болон зардлын хувьд багасгаж чадсан амжилт бий. Ингэснээр аж үйлдвэржсэн ардчиллууд дотроос хамгийн жижиг засгийн газартай, ЭЗХХАБ⁴⁶-ын гишүүн орнууд дотроо хүн амын тоотой нь харьцуулахад хамгийн бага засаг захиргааны ажилтнууд ноогддог улс болоход хүргэсэн. Тухайлбал, 1960-аад онд эхэлж, 1980-д онд дахин эрчимжсэн Захиргааны Шинэтгэлийн Мэргэшсэн Хорооны үйл ажиллагааны дүнд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд ба төрийн өмчит корпорацуудыг багасгах /1960-д онд/, өмч хувьчлал /1980-д онд/ эрчимтэй явуулжээ. 1990-эд оны засаг захиргааны шинэтгэлийн ажлын гол цөм Ерөнхий сайд Хашимотогийн үед хийгдсэн нь түүний засгийн газрын хэрэгжүүлэх нэн тэргүүний ажил болгосон зорилттой холбоотой. Ерөнхий сайд Хашимото 10 жилийн хугацаанд төрийн албан хаагчдын тоог дор хаяж 10%-иар бууруулахыг амлаж байв. Хашимотогийн үед эхлүүлж 1998 оноос Ерөнхий сайд Обучигийн үеэс эрчимтэй хэрэгжүүлэхийг зорьсон шинэтгэлийн багц хөтөлбөрүүд цомхотгол төдийгөөр зогсоогүй хавьгүй өргөн хүрээтэй ажил болсныг хоёр үндсэн чиглэлээр авч үзвэл: нэгд, “Нийтийн шинэ удирдлага” ажлын хүрээнд парламентаас 2001 онд “Бодлогын үнэлгээний тухай хууль”-ийг баталснаар үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах менежментийн шинэ тогтолцоог нэвтрүүлэв. Энэхүү хуулийн төслийг боловсруулахад 1993 оны АНУ-ийн Холбооний засгийн газрын “Засгийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн тухай хууль”-иас санаа авсан хэдий ч Америкчуудыг бодвол яам, агентлагуудад салбарын бодлого, үйл ажиллагаанд оролцох бололцоо, эрх чөлөөг илүүтэй олгосон хууль болсон гэж үздэг⁴⁷. Хоёр дахь чухал арга хэмжээ бол 23 яамдаас бүрдэх төрийн бюрократ тогтолцоог нэг алба ба 12 яамдтай болгож шинэчлэн зохион байгуулсан. Энэ шинэ зохион байгуулалтыг 1998 онд батлаж, 2001 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

⁴⁴ Curtis, 1999: 55.

⁴⁵Inoguchi, T. (1997). Japanese bureaucracy: coping with new challenges. In: Purnendra, J. & Inoguchi, T. Japanese politics today: Beyond karaoke politics? , South Melbourne: Macmillan Education Australia. pp.92-107.

⁴⁶ Эдийн Засгийн Харилцаа, Хамтын Ажиллагааны Байгууллага-1960 онд байгуулагдсан, хөгжингүй орнууд буюу хамгийн өндөр орлоготой эдийн засаг бүхий, хүний хөгжлийн индексээр тэргүүлэгч 35 орныг эгнээндээ багтаасан байгууллага.

⁴⁷Kudo, H. (2003). Between the ‘governance’ model and the Policy Evaluation Act; New Public management in Japan, *Intervational Review of Administrative Sciences*, 69 (4); 483-504.

Эдгээр шинэтгэлийн ажлын чанар, цар хүрээний талаар ялгаатай санал, байр суурьнаас хандаж нэг хэсэг нь Японы бюрократ тогтолцоо урьд хожид байгаагүй уян хатан болж, хөшүүн хойрго тогтолцоогоо эвдэн зөвшилцөл рүү чиглэх болсон⁴⁸ гэж тэмдэглэсэн байхад, зарим судлаачид албан хаагчид эргэн тойрондоо болж буй өөрчлөлтөд сэтгэл дундуур байж, ойлгож хүлээн авах хүртэл нэлээд хугацаа зарцуулах бололтой⁴⁹” хэмээн бичиж байв. Юутай ч 20 дугаар зууны хоёр дугаар хагаст Японы тогтвортой, эдийн засгийн нэн амжилттай улс төрийн систем хэрхэн дотроосоо өөрчлөгдөх болсныг төрийн бюрократ тогтолцооны эрх мэдэл, нэр хүндийн уналт, авлига-хээл хахуультай эвлэрч эс чадах урьдчилан таамаглах аргагүй, няхуур сонгогчидболон бодит байдалтайгаа үл нийцэх шинэтгэлийн талаарх сүржин яриа зэргээс төсөөлж болох байна.

Дуулиант хэргүүдийн шуугианд батлагдсан ёс зүйн хууль

Улс төрийн хүрээний авлига ба ёс зүйгээ алдсан улс төрчдийн талаарх дуулиан шуугиан Японы улс төрд шинэ зүйл биш ээ. Дэлхийн хоёр дугаар дайнаас хойшхи тус улсын түүхийг сөхвөл, арван жил тутамд дор хаяж нэг томоохон авлигын дуулиант хэрэг, хэдэн арван жижиг хахуулийн хэргүүд гарсаар иржээ. 1990-ээд оны байдалтай харьцуулахад эдүгээ хавьгүй эрээ цээргүй, ил тод хутгалдах болжээ. 1988 оны 6 сард ерөнхий сайд Такэшита, Сангийн сайд Миязава, ЛАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Абэ зэрэг нам, төрийн өндөр албан тушаалтнуудын нэр холбогдсон дуулиант хэрэг илчлэгдсэн бол, 1996 онд тусгай зориулалтат асрамжийн газрын барилгын тендер авахад тусалсныхаа шанд бизнесийн бүлэглэлээс хахууль авсан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын дэд сайд баривчлагдсан явдал 1996 оны ёс зүйн хуулийг батлахад чухал нөлөө үзүүлсэн юм.

Судлаачдын үзэж байгаагаар энэ мэт олон тооны зүй бус үйлдлүүд нь төрийн албан хаагчдад хандах иргэдийн итгэлийг бууруулаад зогсохгүй, албан хаагчид өөрийн итгэл, үнэмшлээ алдахад ч нөлөөлдөг гэж үздэг⁵⁰. Бюрократ тогтолцооны ёс зүйн менежментийг сайжруулах шаардлага нь цөөнгүй тооны шийдвэрлэх арга хэмжээ авахад хүргэжээ. Үүнд: юун түрүүн, 1998 оны 12 дугаар сард “Албан хаагчдын сахилга батыг сайжруулах” журам баталж, төрийн албан хаагчид нь иргэдэд эргэлзээ, таамаг төрүүлэхүйц аливаа үйлдлээс ангид байх, 1996 онд Дэд сайд нарын зөвлөлөөс засгийн газрын харьяа яам, агентлаг тус бүрийг үйл ажиллагааны журамтай болохыг үүрэгдэж, гаргасан шийдвэрээрээ эрх ашгийг нь хөндөж болох бүх хувийн болн төрийн хэвшлийн байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллахыг сануулав. Засгийн газрын зүгээс сахилга, дэг журмыг сайжруулах чиглэлд хийсэн энэ мэт алхмууд нь асуудлыг шийдвэрлэх хангалттай гарц шийдэл болж чадахгүй байгааг үргэлжлэн гарах дуулиан шуугиант хэргүүд харуулах болжээ. Ингээд 1998 оны 2 дугаар сард Ерөнхий сайд Хашимото ёс зүйн асуудлыг ул суурьтай хэлэлцэхийн тулд Дэд сайд нарын зөвлөлийн гишүүдээс бүрдсэн хороог байгуулжээ. Уг хороо эрх баригч намууд /ЛАН, СДН ба Сакигаке/ болон сөрөг хүчнийхэнтэй нягт хамтран ажиллаж ёс зүйн хуульд холбогдох хоёр ч хуулийн төслийг Парламентад оруулсан бөгөөд эцэст нь 1999 оны 8 дугаар сарын 13-нд Парламентийн дээд, доод танхимаар батлагдсан ёс зүйн хуулийг батлав. Уг хуулинд:

- Ёс зүйн үндсэн зарчмыг тодорхойлох
- Ёс Зүйн Зөвлөл байгуулах замаар төрийн захиргааны байгууллагуудын хүрээнд ёс зүйн менежментийн зохион байгуулалтын ажлыг хариуцах, “ёс зүйн хяналтын ажилтан” хэмээх үүрэг функцийг нэвтрүүлэх
- Төрийн албан тушаалтнуудын бэлэг, хандивыг тайлагнах журам, төрийн өндөр албан тушаалтнуудын үнэт цаас, орлогын мэдүүлгийг авах журам батлах

⁴⁸Mishima, K. (1998). The changing relationship between Japan's LDP and the bureaucracy. *Asian Survey*, 38 (10): 968-985.

⁴⁹ Campbell, J.C. (1999). Administrative reform as policy change and policy non-change. *Social Science Japan Journal*, 2(2): 157-176.

⁵⁰Mishima, K. (1998): 983-984

- Төрийн өмчийн компаниудын ёс зүйн менежментийн аргууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад ёс зүйн менежментийг нэвтрүүлэх ерөнхий зорилгыг томъёолох зэрэг асуудлыг багтаажээ.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд 1999 онд Ёс зүйн зөвлөлийг Үндэсний Боловсон хүчний байгууллагын /ҮБХБ/ дэргэд байгуулжээ. ҮБХБ нь 1948 онд Америкчуудыг орж ирсний дараа байгуулагдсан бие даасан хараат бус агентлаг юм. Ёс зүйн зөвлөл нь ерөнхийлөгч, 4 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүдийг Засгийн газраас нэр дэвшүүлж томилно. Зөвлөлийн бүтцэд 15 хүнтэй нарийн бчгийн дарга нарын газар багтана. Зөвлөл нь ёс зүйн менежментийн хүрээнд дараахь үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- ❖ Ёс зүйн хуулийн агуулга, нэмэлт өөрчлөлтийн талаар ЗГ-т зөвлөмж хүргүүлэх
- ❖ Ёс зүйн зарчим, дүрэм журмыг зөрчсөн албан хаагчдад авах сахилгын арга хэмжээний стандартыг боловсруулах, хянан нягтлах
- ❖ Ёс зүйн сургалтын хөтөлбөрүүдийг төлөвлөх, зохицуулах
- ❖ Ёс зүйн чиглэлийн судалгааны ажлуудыг гүйцэтгэх
- ❖ Ёс зүйн менежментийн талаар яамд, агентлагуудын удирдлагуудад зөвлөгөө, удирдамж өгөх
- ❖ Бэлэг, орлого, үнэт цаасны гүйлгээний талаархи тайлан мэдээллүүдийг хянах
- ❖ Ёс зүйн хуулийн зөрчлийг эрэн сурвалжлах, зөрчилд тооцох сахилгын арга хэмжээг авах буюу арга хэмжээ авахыг яамдын сайд нарт санал болгох гм.

Ийнхүү Япон улсад төрийн албан хаагчдын нэр хүндийн уналт нь авлига хээл хахуулийн эсрэг шийдвэртэй арга хэмжээ авахыг шаардсан сонгогчдын шаардлагаар нөхцөлдөж, өргөн цар хүрээг хамарсан Ёс зүйн хуулийг 1999 онд боловсруулан хэрэгжүүлэхэд хүргэсэн болохыг дээр өгүүллээ. Цаашид бид уг хуулийг хэрэгжүүлэх явцад хийгдсэн шат дараалсан, өргөн цар хүрээтэй олон алхмуудын талаар дэлгэрүүлэн авч үзнэ. Улмаар Япон төдийгүй хөгжингүй бусад орнуудын төрийн албаны ёс зүй, үзэл суртлын бэхжилтийг хангахад чиглэсэн шилдэг туршлага, ололт амжилтыг судлах замаар өнөөдөр Монголын нийгэм, улс төрийн амьдралд ус агаар мэт хэрэгтэй байгаа хариуцлагатай төр, ёс зүйтэй төрийн албан хаагчдыг төлөвшүүлэх чиглэлд хийж болох дорвитой санал санаачлагуудыг хүргэхийг зорино.

Abstract: In the article, we revealed the importance of public servants ethics and ideology for building welfare state in Japanese case. With the purpose of sharing experiences of success stories of developed states', the topic will be continued in next articles with variety of interesting cases.

НОМ ЗҮЙ

Вандангомбо Р. “Төрийн албаны ёс зүй” УБ., Мөнхийн үсэг ХГ. УБ., 2007

Вебер М. “Улс төр бол мэргэшил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн” Орч. Ү.Нямдорж. УБ., 2000

Галиндэв Б. “Монголын нийгмийн өөрчлөлтийн үе дэх ёс суртахууны асуудлууд” УБ.: 2010

Нитобэ Иназо. “Бушидо: Япон үндэстэний ёс зүйн цогц” Орч. Д.Төмөрбаатар. Ниппон Ньюс СГ. УБ., 2007

Найао, К. (1993). The Japanese prime minister and public policy. Pittsburg: University of Pittsburg Press.

Kerbo, H.R.&McKinstry, J.A. (1995). Who rules Japan? Westport: Praeger Publishers.

Curtis, G.L. (1999). The logic of Japanese politics. New York: Columbia University Press.

Inoguchi, T. (1997). Japanese bureaucracy: Coping with new challenges. In: Purnendra, J. & inoguchi, T. Japanese politics today: Beyond karaoke politics? , South Melbourne: Macmillan Education Australia.

Kudo, H. (2003). Between the ‘governance’ model and the Policy Evaluation Act; New Public management in Japan, *Intervational Review of Administrative Sciences*

- Mishima, K. (1998). The changing relationship between Japan's LDP and the bureaucracy. *Asian Survey*, 38 (10)
- Campbell, J.C. (1999). Administrative reform as policy change and policy non-change. *Social Science Japan Journal*, 2(2)
- Kudo, H & Maesschalk, J. (2006). Japan's national public service ethics law: Background, contents and impact, Leuven, Belgium

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн шинжилгээ: Хямралын менежментбасэтгэл хөдлөлийн улс төр

Ц.Мөнхцэцэг

Доктор, дэд профессор, Улс төрийн коммуникацийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал

This article examines how the 2017 presidential election of Mongolia was held, election campaigns of candidates, and key factors that influenced the election results. In doing so, detailed analyses were done based on the public opinion surveys, media monitoring researches, independent researchers' observation and field study findings.

Keywords: Presidential election, political communication during crisis, emotional politics, digital populism, effect of social network on election campaign

Өгүүллийн товч утга

Энэхүү өгүүлэлд 2017 оны 6 сард явагдсан Монгол улсын ерөнхийлөгчийн долоо дахь удаагийн сонгуулийн үйл явцад нөлөөлсөн хүчин зүйлс, нэр дэвшигчдийн сурталчилгаа, имиж, сонгогчдын зан үйл, сурталчилгааны гол сувгуудыг авч үзсэн болно. Сонгуулийн үйл явцад анализ хийхдээ олон нийтийн санаа бодлын судалгааны дүнгүүд, хэвлэл мэдээллийн мониторингийн судалгаа, хараат бус судлаачдын ажиглалт, хээрийн судалгааны дүнд үндэслэв.

УДИРТГАЛ

2017 оны Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгууль УИХ-д суудалтай Монгол Ардын Нам (МАН), Ардчилсан Нам (АН), Монгол Ардын Хувьсгалт Намын (МАХН) төлөөлөл гурван нэр дэвшигчийн хооронд өрнөлөө. Энэ удаагийн сонгууль нь хэд хэдэн чухал онцлогтой байв. Үүнд:

- Монгол улсын түүхэнд анх удаа ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатанд нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал авч чадалгүй хоёр дахь шатны санал хураалт явагдлаа.
- Өмнөх жилийн парламентын сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан эрх баригч нам ялагдал хүлээв.
- Сонгуулийн кампанид сөрөг сурталчилгаа, нийгмийн сэтгэл хөдлөлд чиглэсэн албан ба албан бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн тактикууд давамгайллаа.
- Аль ч нэр дэвшигчийг дэмжихгүй гэдгээ илэрхийлэн сонгуульд оролцсон иргэдийн хувь ихээхэн өндөр байв.

Улс орны өмнө тулгамдсан эдийн засгийн сорилт, хямрал сонгогчдын санаа бодолд маш хүчтэй нөлөөлдөг. Дэлхийн улс орнуудын ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулиудын